

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2025/067/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:Naranchimegts@audit.gov.mn">Naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:Dolgorsuren@audit.gov.mn">Dolgorsuren@audit.gov.mn</a> Ахлах аудитор П.Амарсанаа Утас: 261648 Цахим хаяг: <a href="mailto:Amarsanaap@audit.gov.mn">Amarsanaap@audit.gov.mn</a> Аудитор Н.Нямсүрэн Утас: 261648 Цахим хаяг: <a href="mailto:Nyamsuren@audit.gov.mn">Nyamsuren@audit.gov.mn</a> Аудитор Ж.Мөнхтуул Утас: 261648 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtuulj@audit.gov.mn">Munkhtuulj@audit.gov.mn</a>
-----------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	<b>4</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	<b>7</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Бизнес төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	11
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	<b>12</b>
3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....	12
3.2 Төрийн өмчит үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.6 Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл .....	15
3.6.2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл .....	15
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	<b>16</b>
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	<b>20</b>
5.1 Албан шаардлага.....	20
5.2 Зөвлөмж .....	22
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	<b>24</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОХУ	Оросын Холбооны Улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТШЗ	Тендер шалгаруулалтын зааварчилгаа
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ТӨРИЙН ҮНЭТ ЦААС ХЭВЛЭЛ  
ТӨОХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Ч.НЯМ-ОЮУН ТАНАА

2026.03.16 № 623  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын сөрөг дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

- Тайлант онд 5,363.3 сая төгрөгийн худалдан авсан түүхий эдийн чанараас шалтгаалан үйлдвэрлэлийн явцад 78.2 төгрөгийн өртөгтэй 1302 ш цахим паспорт чанарын шаардлага хангахгүй хэвлэгдэж, хорогдол үүссэн;
- 2023-2025 онд чанарын шаардлага хангахгүй түүхий эд нийлүүлэгдсэнээс үйлдвэрлэлд орохоос өмнө нийт 1,351.1 сая төгрөгийн үнэтэй 15711 ширхэг дардас, поликарбонат гологдол үүсгэсэн нь үйлдвэрийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөр байна;
- Харилцагч байгууллагатай байгуулсан 403.3 сая төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй;
- Компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулахгүйгээр үйл ажиллагаагаа явуулж, хөрөнгө, мөнгө зарцуулсан, оны эцэст гүйцэтгэлтэй уялдуулан нөхөн батлуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Эдгээр зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2-т “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, 3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” 67 дугаар зүйлийн 1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9-д “Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 2.2-т “Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна” 2.9-д “Захиалагч өөрийн байгууллагын төсвийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө хууль тогтоомжид нийцэж буй эсэх, тухайн байгууллагын зорилтыг хангах, үр ашигтай, зөв төлөвлөгдсөн эсэхийг хянан, цахим системээр батална”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Жорден топпен трейд ХХК-тай байгуулсан 2023 оны 2023/16 дугаар гэрээний 1.5-д “Худалдагч нь олон улсын стандарт, шаардлагын дагуу үйлдвэрлэгдэж, чанарын шаардлага хангасан биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй Үнэт цаасны түүхий эд материал, түүнтэй холбоотой баримт бичгийн хамт худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь худалдагчид гэрээнд заасан нөхцөлөөр төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудитаар баталгаажуулснаас хойш ААНОАТ, НӨАТ, ХХОАТ-ын тайлангаар тооцоо нийлж, бүрэн баталгаажуулаагүй тул ногдуулсан дүнд өөрчлөлт оруулан өр төлбөрийг нэмэгдүүлж, тус үйлдвэрийн татварын тайланд өөрчлөлт орох эсвэл тайлант оны төлбөр дараагийн жилд шилжин төлөгдөж болзошгүй байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК нь Монгол Улсын иргэдийн хувийн болон албаны шугамаар хилээр зорчин нэвтрэх /цахим, энгийн, албан, дипломат/ паспортын бэлдэц үйлдвэрлэж, гүйцэтгэлээр 2024-2025 онд 48,081.2 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Цаашид төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотой хуулийн этгээдийн борлуулалт жил бүр буурах төлөвтэй, үйлдвэрлэх, борлуулах бүтээгдэхүүний төрөл хязгаарлагдмал, хэтийн бизнес төлөвлөгөөгүй байгаа нь урт хугацаанд оршин тогтнож чадахгүй, хөрөнгө оруулалт эргэн нөхөгдөхгүй байх эрсдэлтэй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны аудитын тайланд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн стратегийн бодлогын баримт бичгийн хэлбэрээр өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын “Журам батлах тухай” 2024 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам”-ын хамрах хүрээнд хамаарахгүй Монгол Улсын иргэдийн хилээр зорчих нууцлал бүхий паспортын үйлдвэрлэлд шаардлагатай худалдан авалт, үйлдвэрлэлийн тоо хэмжээ, зарим гүйцэтгэлтэй холбоотой мэдээллүүдийг нарийвчлан дурдаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

  
С.МАГНАЙСҮРЭН

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	92,619,337.51	815,843,285.86
1.1.2	Дансны авлага	-	3,430,665,000.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	720,559,654.60	359,682,029.52
1.1.6	Бараа материал	9,916,732,153.85	14,887,604,567.67
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	-	5,367,335.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>10,729,911,145.96</b>	<b>19,499,162,218.05</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	19,821,305,529.28	17,665,483,384.90
1.2.2	Биет бус хөрөнгө	7,294,279,794.64	5,383,743,853.33
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>27,115,585,323.92</b>	<b>23,049,227,238.23</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>37,845,496,469.88</b>	<b>42,548,389,456.28</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.1.1	Дансны өглөг	2,706,397,404.00	6,575,761,268.41
2.1.1.2	Цалингийн өглөг	68,003,742.00	-
2.1.1.3	Татварын өр	330,781,386.90	3,823,587.59
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	1,503,899.25
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>3,105,182,532.90</b>	<b>6,581,088,755.25</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>3,105,182,532.90</b>	<b>6,581,088,755.25</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	-	-
2.3.1	Төрийн өмч	16,115,170,000.00	16,115,170,000.00
2.3.2	Хувийн өмч	15,483,203,000.00	15,483,203,000.00
2.3.3	Хувьцаат өр төлбөр	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	3,141,940,936.98	4,368,927,701.03
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>34,740,313,936.98</b>	<b>35,967,300,701.03</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>37,845,496,469.88</b>	<b>42,548,389,456.28</b>

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>28,419,939,681.57</b>	<b>19,661,276,363.68</b>
2	Борлуулалтын өртөг	19,003,506,967.02	16,076,307,827.59
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>9,416,432,714.55</b>	<b>3,584,968,536.09</b>
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	43,541,014.47	3,544,325.44
9	Борлуулалт, маркетингийн зардал	27,913,740.76	49,224,449.79
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,911,308,912.63	2,109,837,360.22
11	Санхүүгийн зардал	-	42,200,000.00
12	Бусад зардал	29,237,968.08	24,072,166.38
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	(467,622.02)	139,741.58
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	-	-
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз ( гарз )	-	-
17	Бусад ашиг ( алдагдал )		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>3,491,045,485.53</b>	<b>1,363,318,626.72</b>
19	Орлогын татварын зардал	349,104,548.55	136,331,862.67
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>3,141,940,936.98</b>	<b>1,226,986,764.05</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал )</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>3,141,940,936.98</b>	<b>1,226,986,764.05</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз ( гарз )		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>3,141,940,936.98</b>	<b>1,226,986,764.05</b>
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>		

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-	3,726,014,146.74	3,726,014,146.74
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	31,598,373,000.00	-	-	(3,395,301,690.37)	28,203,071,309.63
3	Залруулсан үлдэгдэл	31,598,373,000.00	-	-	330,712,456.37	31,929,085,456.37
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	(330,712,456.37)	(330,712,456.37)
7	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	3,141,940,936.98	3,141,940,936.98
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	31,598,373,000.00	-	-	3,141,940,936.98	34,740,313,936.98
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	31,598,373,000.00	-	-	3,141,940,936.98	34,740,313,936.98
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
13	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-
14	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
15	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	1,226,986,764.05	1,226,986,764.05
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
17	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	31,598,373,000.00	-	-	4,368,927,701.03	35,967,300,701.03

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	34,066,929,761.98	18,097,953,128.94
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	34,019,041,957.62	18,093,668,444.72
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	47,887,804.36	4,284,684.22
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	33,991,040,826.91	17,374,868,922.17
1.2.1	Ажиллагсад төлсөн	1,821,921,022.50	1,628,612,973.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	153,033,730.55	91,913,700.66
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	30,186,891,084.96	13,820,030,806.17
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	176,843,057.62	137,416,626.38
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	155,529,324.14	118,942,904.87
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,396,407,725.70	1,039,498,937.74
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	100,414,881.44	538,452,973.35
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	75,888,935.07	723,084,206.77
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(467,622.02)	139,741.58
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	75,421,313.05	723,223,948.35
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,198,024.46	92,619,337.51
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	92,619,337.51	815,843,285.86

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Бизнес төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/2025 гүйцэт	Хувь
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>			<b>28,463,480.7</b>	<b>19,138,837.5</b>	<b>19,664,960.4</b>	<b>(8,798,520.3)</b>	<b>69.1</b>	<b>526,122.9</b>	<b>102.7</b>
1	Үйл ажиллагааны орлого	м.төг	28,419,939.7	19,138,837.5	19,661,276.4	(8,758,663.3)	69.2	522,438.8	102.7
	Бусад орлого	м.төг	43,541.0	-	3,544.3	(39,996.7)	8.1	3,544.3	
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз	м.төг	(467.6)	-	139.7	607.3	(29.9)	139.7	
2	<b>Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>28,463,480.7</b>	<b>19,138,837.5</b>	<b>19,664,960.4</b>	<b>(8,798,520.3)</b>	<b>69.1</b>	<b>526,122.9</b>	<b>102.7</b>
3	<b>Нийт зардал</b>	<b>м.төг</b>	<b>24,972,435.2</b>	<b>17,016,447.5</b>	<b>18,301,641.8</b>	<b>(6,670,793.4)</b>	<b>73.3</b>	<b>1,285,194.3</b>	<b>107.6</b>
3	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	5,911,308.9	17,016,447.5	2,109,837.4	(3,801,471.5)	35.7	(14,906,610.1)	12.4
	4	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>м.төг</b>	<b>3,491,045.5</b>	<b>2,122,390.1</b>	<b>1,363,318.6</b>	<b>(2,127,726.9)</b>	<b>39.1</b>	<b>(759,071.5)</b>
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>м.төг</b>	<b>3,141,941.0</b>	<b>1,910,151.1</b>	<b>1,226,986.8</b>	<b>(1,914,954.2)</b>	<b>39.1</b>	<b>(683,164.3)</b>	<b>64.2</b>
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>м.төг</b>	<b>982,205.6</b>	<b>244,999.8</b>	<b>1,344,765.9</b>	<b>362,560.3</b>	<b>136.9</b>	<b>1,099,766.1</b>	<b>548.9</b>
	а/ Орлогын татварт	м.төг		212,239.0	516,256.1	516,256.1		304,017.1	243.2
	б/ НӨТ	м.төг	588,036.3	-	203,207.0	(384,829.3)	34.6	203,207.0	
	в/ НДШ	м.төг	153,033.7	-	91,913.7	(61,120.0)	60.1	91,913.7	
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	234,765.6	-	201,068.9	(33,696.7)	85.6	201,068.9	
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	-	-	-	-		-	
	э/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	-	-	241.1	241.1		241.1	
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгийн хураамж)	м.төг	6,370.0	32,760.8	332,079.1	325,709.1	5,213.2	299,318.3	1,013.6
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	3,726,014.1	-	-	(3,726,014.1)	-	-	
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	57.0	50.0	56.0	(1.0)	98.2	6.0	112.0
9	Нийт цалингийн сан	м.төг	918,528.6	1,725,848.8	1,999,625.1	1,081,096.5	217.7	273,776.3	115.9
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	1,342.9	2,876.4	2,975.6	1,632.8	221.6	99.2	103.4
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.9	0.9	0.9	0.1	106.1	0.0	104.7
12	Хөрөнгө оруулалт	м.төг		48,230.0	-	-		(48,230.0)	-
13	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	<b>720,559.6</b>	<b>-</b>	<b>3,430,665.0</b>	<b>2,710,105.4</b>	<b>476.1</b>	<b>3,430,665.0</b>	
13	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-		-	
	<b>Нийт өглөг</b>	<b>м.төг</b>	<b>3,105,182.5</b>	<b>-</b>	<b>6,581,088.8</b>	<b>3,475,906.2</b>	<b>211.9</b>	<b>6,581,088.8</b>	
14	Богино хугацаат өр төлбөр	м.төг	3,105,182.5	-	6,581,088.8	3,475,906.2	211.9	6,581,088.8	
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	-	-	-	-		-	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн зорилгыг "үндэсний гадаад паспортыг Иргэний нисэхийн байгууллагын шаардлага (ИКАО)-д нийцүүлэн дотооддоо үйлдвэрлэх замаар үндэсний аюулгүй байдлыг хангахад гол дэмжлэг үзүүлэх, үндэсний үнэт цаасны үйлдвэрлэлийн олон улсад өрсөлдөх чадварыг хөгжүүлэхэд оршино" гэж тодорхойлсон байна.

Тус компанийг Засгийн газрын 2023 оны 69 дүгээр тогтоолоор үндэсний цахим гадаад паспортын бэлдцийг үйлдвэрлэх, бичилт хийх төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан байна.

Төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувь эзэмшилд нэг бүр нь 1000 төгрөгийн нийт 31,598,373 ширхэг энгийн хувьцаа байгаагаас Засгийн газрыг төлөөлөн Улсын бүртгэлийн ерөнхий газар 51.0 хувьд 16,115.2 сая төгрөг, Мигасон ХХК 49.0 хувьд 15,483.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийн эзэмшдэг байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй бөгөөд төрийн төлөөлөл 3, хувийн хэвшлийн төлөөлөл 3, хараат бус 3 гишүүн байна.

Тайланд онд ТУЗ-ийн шийдвэрээр Аудитын хороог байгуулсан байна.

Дүрэмд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулахаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндэсний цахим гадаад паспортын бэлдцийг үйлдвэр;
- Үндэсний цахим гадаад паспортын бичилт хийх;
- Үнэт цаас үйлдвэрлэх.

Мөн хууль тогтоомжоор хориглоогүй бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бизнесийн үйл ажиллагаа эрхэлж болно гэж заасан байна.

Тус компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн статустай, өмчийн 51.0 хувийг төр эзэмшиж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяанд үйл ажиллагаа явуулдаг байна.

#### 3.2 Төрийн өмчит үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болгосонд тооцох тухай;
- Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж дүгнэсэн ба нарийвчилсан сорилын хэмжээг бууруулах боломжгүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн 2025 оны 12 дугаар сарын 22-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 25/03 дугаар

**Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

тогтоолоор баталсан бөгөөд тус баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөгдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,049.2 сая төгрөгөөр буюу 15.0 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	92,619.3	815,843.3	723,223.9
Дансны авлага	-	3,430,665.0	3,430,665.0
Татвар, НДШ-ийн авлага	720,559.7	359,682.0	(360,877.6)
Бараа материал	9,916,732.2	14,887,604.6	4,970,872.4
Урьдчилж төлсөн зардал тооцоо	-	5,367.3	5,367.3
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>10,729,911.1</b>	<b>19,499,162.2</b>	<b>8,769,251.1</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	19,821,305.5	17,665,483.4	(2,155,822.1)
Биет бус хөрөнгө	7,294,279.8	5,383,743.9	(1,910,535.9)
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>27,115,585.3</b>	<b>23,049,227.2</b>	<b>(4,066,358.1)</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>37,845,496.5</b>	<b>42,676,521.3</b>	<b>4,831,024.8</b>
<b>Өр төлбөр</b>			
Дансны өглөг	2,706,397.4	6,575,761.3	3,869,363.9
Цалингийн өглөг	68,003.7	-	(68,003.7)
Татварын өр	330,781.4	3,823.6	(326,957.8)
НДШ-ийн өглөг	-	1,503.9	1,503.9
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>3,105,182.5</b>	<b>6,581,088.8</b>	<b>3,475,906.2</b>
Төрийн өмч	16,115,170.0	16,115,170.0	-
Хувийн өмч	15,483,203.0	15,483,203.0	-
Хуримтлагдсан ашиг	3,141,940.9	4,368,927.7	1,226,986.8
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>34,740,313.9</b>	<b>35,967,300.7</b>	<b>1,226,986.8</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>37,845,496.5</b>	<b>42,548,389.5</b>	<b>4,702,893.0</b>

*Эх сурвалж: Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн санхүүгийн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан ашиг данснуудад материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 815.8 сая төгрөг болж, өмнөх оноос 723.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь УБЕГ-аас шилжүүлсэн гадаад паспортын бэлдцийн төлбөр, ГХЯ-аас шилжүүлсэн гэрэгэ системийн төлбөр хүлээн авснаас шалтгаалсан байна;
- Дансны авлага дансны үлдэгдэл 3,430.6 сая төгрөг болж нэмэгдсэн нь УБЕГ-аас авах гадаад паспортын бэлдцийн санхүүжилттэй холбоотой 3,358.6 сая төгрөг, ГХЯ-аас авах паспорт борлуулалтын авлага 72.0 сая төгрөг бүртгэлтэй байна;
- Татвар, НДШ-ийн авлага 359.6 сая төгрөг болж, өмнөх оноос 360.9 сая төгрөгөөр буурсан нь ААНОАТ-ын авлага 107.1 сая төгрөг, НӨАТ-ын авлага 299.8 сая төгрөг, НДШ-ийн авлага 0.6 сая төгрөгөөр тус тус барагдуулсантай холбоотой байна;
- Бараа материал 14,887.6 сая төгрөг болж, өмнөх оноос 4,970.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь түүхий эд материал 39,556.5 сая төгрөгөөр, бараа 11.9 сая төгрөгөөр, хангамжийн материал 54,057.9 сая төгрөгөөр худалдан авч, дуусаагүй үйлдвэрлэлд 35,073.0 сая төгрөг, бэлэн бүтээгдэхүүнд 15,436.7 сая төгрөгийн үйлдвэрлэлийг шилжүүлэн бүртгэж, борлуулснаас голлон шалтгаалсан байна;
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 5.3 сая төгрөг болж нэмэгдсэн нь БНХАУ-аас захиалсан ажлын хувцасны төлбөрөөс шалтгаалсан байна;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,665.5 сая төгрөг болж, 2,155.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлийн зардлаас шалтгаалсан байна;

## Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 6,581.0 сая төгрөг болж, 3,475.9 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:
  - Дансны өглөг 6,575.7 сая төгрөг болж, 3,869.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Жордан топпен трейд ХХК-тай байгуулсан түүхий эд, материал худалдан, худалдан авах гэрээний дагуу өгөх төлбөр;
  - Татварын өр 3,823.6 сая төгрөг болж, 326.9 сая төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны ногдол ашгийн өглөг барагдуулсантай холбоотой байна.
- Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл 4,368.9 сая төгрөг болж, 1,226.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үйл ажиллагааны ашигт ажиллагаатай хамааралтай байна.
- Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 5,383.7 сая төгрөг болж, 1,910.5 сая төгрөгөөр буурсан нь бүртгэлтэй байгаа 23 програм, лицензийн элэгдлээс шалтгаалсан байна. Үүнд:
  - RENAT Enterprise OS License /14ш бүхий 1 багц/, бүртгэлийн дэд системийн лиценз, үүлэнд суурилсан тоон гарын үсгийн платформ, үндэсний нийтийн түлхүүрийн сангийн систем, ГП хэвлэлт удирдлагын программ, иргэний үнэмлэхийн санах ой, мэдээлэл боловсруулах өгөгдлийг удирдах систем, программ /Камер харах/, программ хангамж /МУ-аас хилийн чанад/, программ хангамж /Бүртгэлийн цахим үйлчилгээ/, программ хангамж /Хэвлэгдсэн гадаад паспортын /, программ хангамж /Бүртгэлийн нэгжид/, программ /Улсын бүртгэлийн/, программ /Хурууны хээний/, системийн программ хангамжийн систем, тоон гарын үсгийг ИҮ-ний санах, цахим гарын үсэг олгох бүтцийн систем, цахим паспортын бэлдцэд түлхүүр олгох систем, санхүүгийн даймонд программ тус тус бүртгэлтэй байна.

### 3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал нь жилийн үйлдвэрлэл, санхүүгийн болон эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн ТУЗ-ийн “Үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг баталж, үр дүнг тооцох тухай” 2025 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг оны эцэст нөхөн баталсан нь төсвийн хэрэгжилтийн зарчимд нийцэхгүй байна.

Тайлант онд нийт орлогыг 19,138.8 сая төгрөг, зардлыг 17,016.4 сая төгрөг, цэвэр ашгийг 1,910.1 сая төгрөг, хөрөнгө оруулалтын арга хэмжээний зардлыг 48.2 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 19,664.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, үйл ажиллагаанд 18,301.6 сая төгрөгийг зарцуулж, 1,226.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хөрөнгө оруулалтаар 48.2 сая төгрөгийн тавилга, хэрэгсэл бэлтгэхээр төлөвлөж, тендер зарлахгүйгээр шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 526.1 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар давж биелсэн нь оны эцэст ГХЯ, УБЕГ-ын гадаад паспортын борлуулалтаас шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 18,301.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,285.2 сая төгрөг буюу 7.6 хувиар давж биелсэн байна. Тайлан оны цалингийн зардал төлөвлөснөөс 15.9 хувь буюу 273.8 сая төгрөгөөр хэтэрсэн зэргээс шалтгаалсан байна.

Тайлант оны цэвэр ашиг 1,226.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 683.2 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан нь зардлын хязгаарын хэтрэлтээс шалтгаалсан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу судалгаа авч, дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Хэвлэл, мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээ, хэлцэл байхгүй байна.
- Тайлант онд 2 улсад гадаад томилолтоор ажиллаж, нийт 53.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: БНХГУ-д үйлдвэрлэлийн үзэсгэлэн яармагийн арга хэмжээнд оролцоход 49.8 сая төгрөг, БНХАУ-д хэвлэх үйлдвэрийн туршлага солилцох арга хэмжээнд оролцоход 4.0 сая төгрөг;

- Дотоод аудиторын сургалтад 0.6 сая төгрөг, АЗ сертификат авахад 0.5 сая төгрөг, бусад сургалтад 1.0 сая төгрөг, нийт 2.1 сая төгрөгийг сургалт, семинарын зардалд зарцуулсан байна.

### **3.6 Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл**

#### **3.6.2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл**

Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөө батлах тухай” 2025 оны А/08 дугаар тушаалаар урсгал болон хөрөнгө оруулалтын төсвөөр худалдан авах арга хэмжээг баталж, тайлант онд 2025 оны А/239, А/105 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын багцад гадаад паспортын бэлдэц худалдан авах 22,933.3 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 16,663.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төрийн өмчит үйлдвэрийн газар, түүний гадаад, дотоод орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төр, хувийн хэвшлийн оролцоотой хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг шинэчлэн тогтоох, үнэлгээ хийлгэх, ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл, иж бүрэн тайлагнах, зорилтот түвшин, орон тоо, цалингийн гүйцэтгэл, санхүү, нягтлан бодох бүртгэлийн программын нууцлалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Амарсанаа, аудитор Н.Нямсүрэн, Ж.Мөнхтуул нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг 2026 оны 02 дүгээр сарын 12-ний өдрийн 1-1/21 дугаарт албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 28,463.4 сая төгрөгийн 1 хувиар буюу 284.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гадаад паспорт үйлдвэрлэлийн түүхий эд худалдан авах санхүүжилт төсвийн орлогын тасалдлаас шалтгаалан бүрэн хэрэгжээгүй боловч шаардлагатай үед зарцуулах үлдэгдэл нөөцөөр энэ оны 11 сар хүртэл үйл ажиллагаа явуулахаар байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотой хуулийн этгээдийн жилийн зорилтот түвшин, бизнес төлөвлөгөө, өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулахгүйгээр үйл ажиллагаагаа явуулж, хөрөнгө, мөнгө зарцуулсан, оны эцэст гүйцэтгэлтэй уялдуулан нөхөн батлуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2-т “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, 21 дүгээр зүйлийн 1-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид “зорилтын санал” гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, 24 дүгээр зүйлийн 1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Сангийн яамаар зардлын дээд хязгаарыг батлуулна”, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.2-т “хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах”, Компанийн дүрмийн 8.2.2-т “Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн зорилтот түвшин, бизнес төлөвлөгөө, төсвийн төсөөллийг бэлтгэн, боловсруулж, батлуулаагүй буруутай албан тушаалтныг олж тогтоон сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт: Төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотой этгээдийн засаглал, хэтийн бизнес төлөвлөгөө, үндсэн үйл ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Компани засаглалын хувьд төлөвшөөгүй, стратеги төлөвлөгөө байхгүйгээс Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг оны эцэст буюу 12 дугаар сард хийж, тайлант онд төлөвлөгөөгүй ажилласан;
- Үйлдвэрийн зарим үйл ажиллагаа түр зогссон, ашигт ажиллагаа буурсан нь цаашид компанийн хэвийн үйл ажиллагаанд эрсдэл учруулж, үйлдвэрлэл тасалдах, Монгол Улсын иргэдийн зорчих эрхэд сөрөг нөлөө үүсэх эрсдэлтэй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13-т “төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах”, Санхүүгийн зохицуулах хорооны “Компанийн засаглалын кодексийг батлах тухай” 2022 оны 145 дугаар тогтоолын зарчим 1-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт”, зарчим 2-т “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг”, зарчим 3-т “Тайлагнал, мэдээллийн ил тод байдал”, зарчим 4-т “Аудит, хяналтын тогтолцоо”, зарчим 5-д “Эрсдэлийн удирдлага”, зарчим 6-д “Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал”, зарчим 7-д “Оролцогч талуудын эрх ашиг”, зарчим 8-д “Компанийн соёл”, зарчим 9-д “Хувьцаа эзэмшигчдийн эрх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн засаглалыг төлөвшүүлээгүй, стратеги төлөвлөгөөгүй ажилласан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төрийн аудитын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн дүрэм болон хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

## Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 34,070.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 34,033.9 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгч, хариуцлага тооцох албан шаардлага 1 хүргүүлсэн байна.

Улсын бүртгэлийг ерөнхий газрын харьяа байгууллагуудын зөрчлийг арилгах, арга хэмжээний төлөвлөгөөг нэгтгэн, 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 1/5975 дугаар албан бичгээр ирүүлж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 1-1/103 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлсэн нотлох баримтад тулгуурлан үнэлэхэд хэрэгжилт 75.0 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелсэн		Биелэгүй		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	36.4	1	36.4			100.0
Албан шаардлага	6	34,033.9	3	27,923.7	3	6,110.2	50.0
Зөвлөмж	2	-	1	-	1	-	50.0
Хариуцлага тооцох албан шаардлага	1	-	1	-	0	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>34,070.3</b>	<b>6</b>	<b>27,960.1</b>	<b>4</b>	<b>6,110.2</b>	<b>75.0</b>

Аудитын дараах шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 24/03 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын шинжтэй худалдан авалт хийхдээ, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарт заасныг зөрчин 141,725.1 мянган төгрөгийн барааг нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулахгүйгээр харьцуулалтын арга ашиглан худалдан авсныг арилгах албан шаардлага биелээгүй, 2025 оны төсөв, төлөвлөгөөг жилийн эцсээр баталсан;
- Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хийж, хүчингүй болсон журамд үндэслэн, 2025 оны 25/06 дугаар тогтоолоор ТУЗ-ийн сарын цалинг үндэслэлгүй нэмж, 1,584.0 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэх захиралтай хийсэн гэрээг дүгнэхгүйгээр 9.0 хувиар тооцон 297,105.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан;
- Тайлант оны бизнес төлөвлөгөөг тухайн оны эхэнд төлөвлөж, хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлээгүй, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж батлуулаагүй зөрчлийг давтан гаргаж, ТУЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 25/03 дугаар тогтоолоор компанийн 2025 оны зорилтот түвшнийг баталж, өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна;
- Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн бүтэц, орон тоо, цалингийн санд багтааж, ажиллах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, 2025 онд цалингийн зардлыг хэтрүүлэн зарцуулсан.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад дараах асуудлыг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдахгүй хуримтлагдсан түүхий эдийг гэрээний дагуу нийлүүлэгчтэй тохиролцож, ашигт ажиллагаанд нөлөөлөх эрсдэлийг бууруулсан эсэх;
- Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор тус компанийн албаны нууцад оруулсан мэдээлийг ил болгосон эсэх;
- Төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотой хуулийн этгээдийн мөнгөн урсгал, санхүүжилтийн дутагдлын эрсдэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын орлого

## Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

төвлөрүүлдэг дансны үйл ажиллагаа, хэрхэн төсвийн хяналт хэрэгжүүлэх асуудлыг нэгтгэн дүгнэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,788.3 сая төгрөгийн 3 алдааг илрүүлж, аудитын явцад залрууллаа.

### **Залруулсан алдаа:**

- Татварын байгууллагаас авах 34.4 сая төгрөгийн НӨАТ-ын авлагыг санхүүгийн тайланд 265.3 сая төгрөгөөр илүү тусгасан байгаа нь УСНББОУС-3 “НББ-ийн бодлого, НББ-ийн тооцооллын өөрчлөлт ба алдаа” хэсэг, толилуулга ба тодруулга, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
- Мүүр Аудит ХХК-тай зөвлөх үйлчилгээ үзүүлэх 17.2 сая төгрөгийн гэрээ байгуулж, 9.0 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлж, гэрээний 8.2 сая төгрөгийн үлдэгдлийг өглөг үүсгэж, бүртгээгүй байгаа нь УСНББОУС-3 “НББ-ийн бодлого, НББ-ийн тооцооллын өөрчлөлт ба алдаа” хэсэг, толилуулга ба тодруулга, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
- Жордан топпен ХХК-аас нийт 16,663.2 сая төгрөгийн 2 нэр төрлийн түүхий эд материал худалдан авч, орлого болгож бүртгэсэн боловч 1,514.8 сая төгрөгийн НӨАТ-ыг бүртгэж тайлагнаагүй, санхүүжилтийн зөрүү үүсгэсэн байгаа нь УСНББОУС-3 “НББ-ийн бодлого, НББ-ийн тооцооллын өөрчлөлт ба алдаа” хэсэг, толилуулга ба тодруулга, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 2,074.9 сая төгрөгийн 8 зөрчил<sup>1</sup> илэрсэнд 1,926.9 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 148.0 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн асуудалд 2 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 2,074.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,790.3 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### **5.1 Албан шаардлага**

#### **Харилцагч талуудтай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнэх, тооцоо нийлж, баталгаажуулахтай холбоотой асуудал**

Илрүүлэлт 1. Тайлант онд Мигасон ХХК-тай байгуулсан 403.3 сая төгрөгийн, Монгол даатгал ХХК-тай байгуулсан 17.9 сая төгрөгийн, Чэк мэйт ХХК-тай байгуулсан 8.2 сая төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

#### **Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн түүхий эдийн ашиглалт, элэгдэл, хорогдолтой холбоотой асуудал**

Илрүүлэлт 2. Тайлант онд цахим гадаад паспорт үйлдвэрлэхэд ашигладаг 137200 ширхэг поликарбонатыг 5,363.3 сая төгрөгөөр худалдан авсан байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад түүхий эдийн чанараас шалтгаалан жилийн эцсийн байдлаар 78.2 сая төгрөгийн өртөгтэй 1302 ширхэг цахим паспорт чанарын шаардлага хангахгүй хэвлэгдэж, хорогдол үүссэн;

Илрүүлэлт 3. Компанийн хэмжээнд 2023-2025 онд нийт 15711 ширхэг, 1,351.1 сая төгрөгийн үнэтэй поликарбонат гологдол үүсгэсэн, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд орохоос өмнө

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

чанарын шаардлага хангахгүй, түүхий эд нийлүүлэгдсэн нь балансын болон үйлдвэрлэлийн ашигт ажиллагааны нөлөөлж алдагдал хүлээж, болзошгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагаанаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түүхий эдүүдийг худалдан авахдаа олон улсын болон үндэсний үйлдвэрлэлийн стандартад нийцэж буй эсэхэд хяналт тавьж, алдагдлыг бууруулах бодлогыг баримталж, чанарын шаардлага хангахгүй түүхий эд хүлээн авдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

#### **Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт 4.** Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлахгүйгээр нийт 36.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;

**Илрүүлэлт 5.** Харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагаа зохион байгуулж, гэрээ байгуулахгүйгээр Шунхлай ХХК-аас 23.2 сая төгрөгийн шатахууныг худалдан авсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9-т "Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", Сангийн сайдын 2023 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/250 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" 2.9-т "Захиалагч өөрийн байгууллагын төсвийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө хууль тогтоомжид нийцэж буй эсэх, тухайн байгууллагын зорилтыг хангах, үр ашигтай, зөв төлөвлөгдсөн эсэхийг хянан, цахим системээр батална" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, батлахгүйгээр хөрөнгө бэлтгэсэн, гэрээ байгуулахгүйгээр бараа, бүтээгдэхүүн худалдан авдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

#### **Гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлсэн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэл, хяналттай холбоотой асуудал**

**Илрүүлэлт 6.** Тайлант онд Мүүрь аудит ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр МА-2025-ЗҮ-01 дугаар "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ"-г байгуулж, 9.0 сая төгрөгийн урьдчилгаа төлсөн боловч гүйцэтгэл хангалтгүй, компанийн үйл ажиллагаанд тохирсон дансны харьцаа, бүртгэл, хөрөнгийн элэгдэл тооцох аргачлал тусгаагүй, захиалагчийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК, Мүүрь аудит ХХК-тай байгуулсан МА-2025-3Ү-01 дугаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээ гэрээ”-ний 2.1.2-т “Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн боловсруулсан бодлогын баримт бичгийг гэрээний хугацаанд дуусахаас өмнөх хүлээн авч өмчлөх эрхтэй”, 4.5-д “Талууд харилцан тохиролцож, гэрээнд өөрчлөлт оруулсан, цуцалснаас бусад тохиолдолд гэрээ нь хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 90 хоногийн дотор хүчинтэй байна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон, хэрэгцээ шаардлагад нийцсэн бодлогын баримт бичиг боловсруулаагүй, ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Хувьцаа эзэмшигчдийн оруулсан хувь оролцоо, хөрөнгийн бодит үнэ цэнийн дахин үнэлгээ, балансын болон үйлдвэрлэлийн ашигт ажиллагаа, ирээдүйд тохиолдох эрсдлийг бууруулахтай холбоотой асуудал**

Илрүүлэлт 1. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн дүрмийн сан 31,598.4 сая төгрөг байгаагаас 51 хувь эзэмшигчийн оруулсан хөрөнгө 16,115.2 сая төгрөг, 49 хувь эзэмшигчийн оруулсан хөрөнгө 15,483.2 сая төгрөгийг талууд тус тус хувь нийлүүлэн үйл ажиллагаа явуулж байна. Харин дээрх хуулийн этгээд цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах, компанийн засаглалын кодексийг бий болгох, санхүү, эдийн засгийн харилцаанд ороход хувь нийлүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоохгүй байгаа нь хувь эзэмшлийн маргаан үүсэх, ашигт ажиллагаа буурах, үндсэн үйл ажиллагаа доголдох зэрэг сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 20 дугаар зүйлийн 2-т “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3-т “төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийг өөрчлөхөд”, ТУЗ-ийн 2024 оны 10 дугаар сарын 17-ний өдрийн 24/03 дугаар “Хөрөнгийн үнэлгээ хийх шийдвэр гаргах тухай” тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотой хуулийн этгээдийн оруулсан хөрөнгийн бодит үнэ цэнийг хууль тогтоомжийн хүрээнд үнэлүүлж, бүртгэл тайланд тусгах, ирээдүйд учирч болзошгүй хөрөнгө оруулалт, ашигт ажиллагаанд нөлөөлөх эрсдлийг бууруулах бодлогын арга хэмжээг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэж, үр дүн, тооцоо судалгааг тайлагнах зөвлөмж өгөв.

**Батлагдсан зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөнд тусгагдсан төсвийн хязгаарын хүрээнд зарцуулалт хийх, төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг сайжруулахтай холбоотой асуудал**

Илрүүлэлт 2. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 25/03 дугаар тогтоолоор бүтэц орон тооны дээд хязгаарыг 50 ажилтантай байхаар баталсан боловч НД-ын 12 дугаар сарын тайланд үндсэн 51 ажилтан, жирэмсэн, тэтгэвэрт гарсан 5, нийт 65 албан хаагчаар тайлагнасан. Мөн зорилтот түвшинг 49.4 сая төгрөгөөр хэтрүүлж, 1,981.4 сая төгрөгийг цалингийн зардалд зарцуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 20 дугаар зүйлийн 2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийх, төсвийн хэрэгжилтийн зарчмыг баримталж, сар, улирал, жилээр мөнгөн урсгалтай уялдуулан төлөвлөж, гүйцэтгэлийг тухай бүр хянаж ажиллах зөвлөмж өгөв.

### **Бүртгэлээр тавих дотоод хяналтын тогтолцоог бий болгохтой холбоотой асуудал**

**Илрүүлэлт 3.** Ажил, гүйлгээ гарсныг нотлох, гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт, бусад нотолгоо буюу анхан шатны 98.6 сая төгрөгийн баримтыг үнэн, зөв, иж бүрэн бүрдүүлж, ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ажил гүйлгээг анхан шатны төлбөрийн болон бусад дэмжих баримтанд үндэслэж хийх, гүйлгээ хийх, хянаж баталгаажуулах албан тушаалтан хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх зөвлөмж өгөв.

### **Санхүү, бүртгэлийн үйл ажиллагааны хараат бус байдал, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг сайжруулахтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт 4.** Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа явуулдаг Даймонд программын үндсэн эх код, эзэмшигч нь тус үйлдвэрийн хувьцаа эзэмшигч Мигасон ХХК байгаа нь санхүү, төсвийн үйл ажиллагаа хараат бусаар хэрэгжих, хөгжүүлэлт хийх, нууцлалын шаардлага хангахгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 5-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох", 7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотой этгээдийн эзэмшил, бүртгэл тайланд тусгах, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанд гарган УАГ-т ирүүлж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Татварын байгууллагаас авах 34.4 сая төгрөгийн НӨАТ-ын авлагыг санхүүгийн тайланд 265.3 сая төгрөгөөр илүү тусгасан байна.	1	265,278.1			1	265,278.1	1	265,278.1				
Мүүр Аудит ХХК-тай зөвлөх үйлчилгээ үзүүлэх 17.2 сая төгрөгийн гэрээ байгуулж, 9.0 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлж, гэрээний 8.2 сая төгрөгийн үлдэгдлийг өглөг үүсгэж, бүртгээгүй байна.	1	8,200.0			1	8,200.0	1	8,200.0				
Жордан топлен ХХК-аас нийт 16,663.2 сая төгрөгийн 2 нэр төрлийн түүхий эд материал худалдан авч, орлого болгож бүртгэсэн боловч 1,514.8 сая төгрөгийн НӨАТ-ыг бүртгэж тайлагнаагүй, санхүүжилтийн зөрүү үүсгэсэн байна.	1	1,514,839.5			1	1,514,839.5	1	1,514,839.5				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1,788,317.6</b>			<b>3</b>	<b>1,788,317.6</b>	<b>3</b>	<b>1,788,317.6</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Тайлант онд Мигасон ХХК-тай байгуулсан 403.3 сая төгрөгийн, Монгол даатгал ХХК-тай байгуулсан 17.9 сая төгрөгийн, Чэк мэйт ХХК-тай байгуулсан 8.2 сая төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.	1	429,150.0			1	429,150.0		
1. Тайлант онд цахим гадаад паспорт үйлдвэрлэхэд ашигладаг 137200 ширхэг поликарбонатыг 5,363.3 сая төгрөгөөр худалдан авсан байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад түүхий эдийн чанараас шалтгаалан жилийн эцсийн байдлаар 78.2 сая төгрөгийн өртөгтэй 1302 ширхэг цахим паспорт чанарын шаардлага хангахгүй хэвлэгдэж, хорогдол үүссэн; 2. Компанийн хэмжээнд 2023-2025 онд нийт 15711 ширхэг, 1,351.1 сая төгрөгийн үнэтэй поликарбонат гологдол үүсгэсэн, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд орохоос өмнө чанарын шаардлага хангахгүй, түүхий эд нийлүүлэгдсэн нь балансын болон үйлдвэрлэлийн ашигт ажиллагааны нөлөөлж алдагдал хүлээж, болзошгүй байна.	1	1,429,397.5			1	1,429,397.5		
1. Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлахгүйгээр нийт 36.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй; 2. Харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагаа зохион байгуулж, гэрээ байгуулахгүйгээр Шунхлай ХХК-аас 23.2 сая төгрөгийн шатахууныг худалдан авсан.	1	59,407.5			1	59,407.5		
1. Тайлант онд Мүүрь аудит ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр МА-2025-ЗҮ-01 дугаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ”-г байгуулж, 9.0 сая төгрөгийн урьдчилгаа төлсөн боловч гүйцэтгэл хангалтгүй, компанийн үйл ажиллагаанд тохирсон дансны харьцаа, бүртгэл, хөрөнгийн элэгдэл тооцох аргачлал тусгаагүй, захиалагчийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй байна.	1	9,000.0			1	9,000.0		
Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн дүрмийн сан 31,598.4 сая төгрөг байгаагаас 51 хувь эзэмшигчийн оруулсан хөрөнгө 16,115.2 сая төгрөг, 49 хувь эзэмшигчийн оруулсан хөрөнгө 15,483.2 сая төгрөгийг талууд тус тус хувь нийлүүлэн үйл ажиллагаа явуулж байна. Харин дээрх хуулийн этгээд цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах, компанийн засаглалын кодексийг бий болгох, санхүү, эдийн засгийн харилцаанд ороход хувь нийлүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоохгүй байгаа нь хувь эзэмшлийн маргаан үүсэх, ашигт ажиллагаа буурах, үндсэн үйл ажиллагаа доголдох зэрэг сөрөг нөлөө үзүүлэхээр байна.	1	-				-	1	-

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 25/03 дугаар тогтоолоор бүтэц орон тооны дээд хязгаарыг 50 ажилтантай байхаар баталсан боловч НД-ын 12 дугаар сарын тайланд үндсэн 51 ажилтан, жирэмсэн, тэтгэвэрт гарсан 5, нийт 65 албан хаагчаар тайлагнасан. Мөн зорилтот түвшинг 49.4 сая төгрөгөөр хэтрүүлж, 1,981.4 сая төгрөгийг цалингийн зардалд зарцуулсан.	1	49,415.9					-	1	49,415.9
Ажил, гүйлгээ гарсныг нотлох, гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт, бусад нотолгоо буюу анхан шатны 98.6 сая төгрөгийн баримтыг үнэн, зөв, иж бүрэн бүрдүүлж, ажиллаагүй байна.	1	98,588.2					-	1	98,588.2
Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа явуулдаг Даймонд программын үндсэн эх код, эзэмшигч нь тус үйлдвэрийн хувьцаа эзэмшигч Мигасон ХХК байгаа нь санхүү, төсвийн үйл ажиллагаа хараат бусаар хэрэгжих, хөгжүүлэлт хийх, нууцлалын шаардлага хангахгүй байна.	1	-					-	1	-
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>2,074,959.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>1,926,955.0</b>	<b>4</b>	<b>148,004.1</b>	

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Албан шаардлага		Сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК нь үйлдвэрийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулахгүйгээр төсвийг зарцуулж, оны эцэст гүйцэтгэлтэй уялдуулан нөхөж батлуулсан;	1	-			1	-	-	-	-
1. Компани засаглалын хувьд төлөвшөөгүй, стратеги төлөвлөгөө байхгүйгээс Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг оны эцэст буюу 12 дугаар сард хийж, тайлант онд төлөвлөгөөгүй ажилласан; 2. Үйлдвэрийн зарим үйл ажиллагаа түр зогссон, ашигт ажиллагаа буурсан нь цаашид компанийн хэвийн үйл ажиллагаанд эрсдэл учруулж, үйлдвэрлэл тасалдах, Монгол Улсын иргэдийн зорчих эрхэд сөрөг нөлөө үүсэх эрсдэлтэй байна.	1	-	1	-		-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>1</b>		<b>1</b>				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 724/АД170064

Улаанбаатар хот

САГ-2026/67/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

1. Тайлант онд цахим гадаад паспорт үйлдвэрлэхэд ашигладаг 137200 ширхэг поликарбонатыг 5,363,272,727.27 (Таван тэрбум гурван зуун жаран гурван сая хоёр зуун далан хоёр мянга долоон зуун хорин долоон төгрөг хорин долоон мөнгө)-өөр худалдан авсан байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад түүхий эдийн чанараас шалтгаалан жилийн эцсийн байдлаар 78,251,502.00 (Далан найман сая хоёр зуун тавин нэгэн мянга таван зуун хоёр) төгрөгийн өртөгтэй 1302 ширхэг цахим паспорт чанарын шаардлага хангахгүй хэвлэгдэж, хорогдол үүссэн;
2. Компанийн хэмжээнд 2023-2025 онд нийт 15711 ширхэг, 1,351,146,000.00 (Нэг тэрбум гурван зуун тавин нэгэн сая нэг зуун дөчин зургаан мянган) төгрөгийн үнэтэй поликарбонат гологдол үүсгэсэн, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд орохоос өмнө чанарын шаардлага хангахгүй, түүхий эд нийлүүлэгдсэн нь балансын болон үйлдвэрлэлийн ашигт ажиллагааны нөлөөлж алдардал хүлээж, болзошгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", 67 дугаар зүйлийн 1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Жорден топпен трейд ХХК-тай байгуулсан 2023 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 2023/16 дугаар гэрээний 1.5-т "Худалдагч нь олон улсын стандарт, шаардлагын дагуу үйлдвэрлэгдэж, чанарын шаардлага хангасан биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй үнэт цаасны түүхий эд материал, түүнтэй холбоотой баримт бичгийн хамт худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь худалдагчид гэрээнд заасан нөхцөлөөр төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230


Z:\Alban Shaardlaga\2026.0316.SAG-35.Docx

1526180898

акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түүхий эдүүдийг худалдан авахдаа олон улсын болон үндэсний үйлдвэрлэлийн стандартад нийцэж буй эсэхэд хяналт тавьж, алдагдлыг бууруулах бодлогыг баримталж, чанарын шаардлага хангахгүй түүхий эд хүлээн авдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн гүйцэтгэх захирал (Ч.Ням-Оюун), Ерөнхий нягтлан бодогч (Б.Лхагвасүрэн) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
П.АМАРСАНАА  
Н.НЯМСҮРЭН  
Ж.МӨНХТУУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 725/A0170064

Улаанбаатар хот

САГ-2026/67/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

1. Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлахгүйгээр нийт 36,167,455.00 (Гучин зургаан сая нэг зуун жаран долоон мянга дөрвөн зуун тавин таван) төгрөгийн хөрөнгө худалдан авч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;
2. Харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагаа зохион байгуулж, гэрээ байгуулахгүйгээр Шунхлай ХХК-аас 23,240,000.00 (Хорин гурван сая хоёр зуун дөчин мянган) төгрөгийн шатахууныг худалдан авсан.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохио байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9-т "Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", Сангийн сайдын 2023 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/250 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" 2.9-т "Захиалагч өөрийн байгууллагын төсвийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө хууль тогтоомжид нийцэж буй эсэх, тухайн байгууллагын зорилтыг хангах, үр ашигтай, зөв төлөвлөгдсөн эсэхийг хянан, цахим системээр батална" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудитарын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, батлахгүйгээр хөрөнгө бэлтгэсэн, гэрээ байгуулахгүйгээр бараа, бүтээгдэхүүн худалдан авдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн гүйцэтгэх захирал (Ч.Ням-Оюун), Ерөнхий нягтлан бодогч (Б.Лхагвасүрэн) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
П.АМАРСАНАА  
Н.НЯМСҮРЭН  
Ж.МӨНХТУУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 726/А0170064

Улаанбаатар хот

САГ-2026/67/КА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд Мигасон ХХК-тай байгуулсан 403,355,785.00 (Дөрвөн зуун гурван сая гурван зуун тавин таван мянга долоон зуун наян таван) төгрөгийн, Монгол даатгал ХХК-тай байгуулсан 17,925,000.00 (Арван долоон сая есөн зуун хорин таван мянган) төгрөгийн, Чэк мэйт ХХК-тай байгуулсан 8,200,000.0 (Найман сая хоёр зуун мянган) төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харилцагч байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ын гүйцэтгэх захирал (Ч.Ням-Оюун), Ерөнхий нягтлан бодогч (Б.Лхагвасүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
П.АМАРСАНАА  
Н.НЯМСҮРЭН  
Ж.МӨНХТУУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 727/А0170064

Улаанбаатар хот

САГ-2026/67/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Компани засаглалын хувьд төлөвшөөгүй, стратеги төлөвлөгөө байхгүйгээс Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг оны эцэст буюу 12 дугаар сард хийж, тайлант онд төлөвлөгөөгүй ажилласан;
- Үйлдвэрийн зарим үйл ажиллагаа түр зогссон, ашигт ажиллагаа буурсан нь цаашид компанийн хэвийн үйл ажиллагаанд эрсдэл учруулж, үйлдвэрлэл тасалдах, Монгол Улсын иргэдийн зорчих эрхэд сөрөг нөлөө үүсэх эрсдэлтэй байна.


Энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13-т "төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах", Санхүүгийн зохицуулах хорооны "Компаний засаглалын кодексийг батлах тухай" 2022 оны 145 дугаар тогтоолын зарчим 1-д "Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт", зарчим 2-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг", зарчим 3-т "Тайлагнал, мэдээллийн ил тод байдал", зарчим 4-т "Аудит, хяналтын тогтолцоо", зарчим 5-д "Эрсдэлийн удирдлага", зарчим 6-д "Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал", зарчим 7-д "Оролцогч талуудын эрх ашиг", зарчим 8-д "Компанийн соёл", зарчим 9-д "Хувьцаа эзэмшигчдийн эрх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Компанийн засаглал төлөвшөөгүй, стратеги төлөвлөгөөгүй ажиллаж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн гүйцэтгэх захирал (Ч.Ням-Оюун), Ерөнхий нягтлан бодогч (Б.Лхагвасүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
П.АМАРСАНАА  
Н.НЯМСҮРЭН  
Ж.МӨНХТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261130

Z: Alban Shaardlaga 2026 0316 SAG-35.Docx

1526180902



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 728/АД170064

Улаанбаатар хот

САГ-2026/67/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ

Тайлант онд Мүүрь аудит ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр МА-2025-ЗҮ-01 дугаар "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ"-г байгуулж, 9,000,000.00 (Есөн сая) төгрөгийн урьдчилгаа төлсөн боловч гүйцэтгэл хангалтгүй, компанийн үйл ажиллагаанд тохирсон дансны харьцаа, бүртгэл, хөрөнгийн элэгдэл тооцох аргачлал тусгаагүй, захиалагчийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК, Мүүрь аудит ХХК-тай байгуулсан МА-2025-ЗҮ-01 дугаар "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээ гэрээ"-ний 2.1.2-т "Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн боловсруулсан бодлогын баримт бичгийг гэрээний хугацаанд дуусахаас өмнөх хүлээн авч өмчлөх эрхтэй", 4.5-д "Талууд харилцан тохиролцож, гэрээнд өөрчлөлт оруулсан, цуцалснаас бусад тохиолдолд гэрээ нь хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 90 хондгийн дотор хүчинтэй байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон, хэрэгцээ шаардлагад нийцсэн бодлогын баримт бичиг боловсруулаагүй, ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн гүйцэтгэх захирал (Ч.Ням-Оюун), Ерөнхий нягтлан бодогч (Б.Лхагвасүрэн) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
П.АМАРСАНАА  
Н.НЯМСҮРЭН  
Ж.МӨНХТУУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 729/А0170064

Улаанбаатар хот

САГ - 2026/67/НА - СТА - ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудит хийх явцад өмнөх аудитаар өгсөн 877, 882 дугаартай албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК нь үйлдвэрийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулахгүйгээр төсвийг зарцуулж, оны эцэст гүйцэтгэлтэй үйлдүүлэн нөхөж батлуулсан;


Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд сазд учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэргүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 21 дүгээр зүйлийн 1-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид "зорилтын санал" гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 24 дүгээр зүйлийн 1-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Сангийн яамар зардлын дээд хязгаарыг батлуулна", Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.2-т "хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах", Компанийн дүрмийн 8.2.2-т "Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн

42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эдийн засгийн зорилтот түвшин, бизнес төлөвлөгөө, төсвийн төсөөллийг бэлтгэн, боловсруулж, батлуулаагүй буруутай албан тушаалтныг олж тогтоон сахилгын хариуцлага оногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
П.АМАРСАНАА  
Н.НЯМСҮРЭН  
Ж.МӨНХТУУЛ